

## XACBANK BOARD MEETING 8<sup>th</sup> December 2021

As an independent member, I attended by video conferencing the above-mentioned meeting.

In my opinion, the Board papers were circulated sufficiently ahead of time giving me sufficient time to study the documents in preparation of the meeting.

The Board went over the agenda items and, after reports by the chairpersons of each board committee approved the recommendations of these various board committees.

I commented on the remuneration of the members of the Board when the GNCC recommended the board budget for approval to be proposed to the shareholders.

In my opinion, each member of the board has a fiduciary responsibility vis a vis the bank and all shareholders, even those individuals who have been nominated by a shareholder. As such each board member is to have the same remuneration, except the chairperson given the additional responsibilities of the position. However, I remarked that the level of compensation has to be an appropriate level that the chairperson would remain independent. There could be a risk of a loss of independence if the remuneration is at a level that this becomes a significant share of that person's revenue.

Management presented an update on the IPO project infirming the completion of the merger of XacLeasing and XacBank.

The Board reviewed and discussed the economic and banking update presented by management.

The Board reviewed and approved the 2022 Budget and the KPI of the CEO for 2022 following some changes proposed and agreed by the Board.

As an independent member I was able to vote freely on all the resolutions.

Except for the remuneration of members of the board which was a recommendation to shareholders for their decision, there was no item that could have given rise to a conflict of interest for any member of the board.

Members were encouraged and allowed to participate and express opinions freely.

Prepared by

Lim Sit Chen Lam Pak Ng (Maurice Lam)



22<sup>nd</sup> December, 2021

## ТУЗ-ИЙН 2021 ОНЫ 12-Р САРЫН 8-НЫ ӨДРИЙН ХУРЛЫН ТАЙЛАН

Хараат бус гишүүний хувьд дээр дурьдсан хуралд видео холбооны хэрэгслээр дамжуулан оролцсон.

ТУЗ-ийн хурлын материалуудыг хурлаас өмнө тарааж, хурлаар хэлэлцэх асуудлуудыг урьдчилан судалж, ТУЗ-өөс гарах шийдвэрүүдийн талаар өөрийн байр суурийг тодорхойлоход хангалттай цаг хугацаа олгосон.

ТУЗ-ийн хурлаар ТУЗ-ийн хороодын дарга нар хороодын тайланг танилцуулж, ТУЗ-ийн хороодоос гаргасан зөвлөмжүүдийг хэлэлцэж баталсан.

Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооноос ТУЗ-ийн төсвийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар оруулж батлуулах зөвлөмж гаргаж танилцуулахад ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын талаар өөрийн байр суурийг илэрхийлж санал бодлоо хуваалцсан.

Миний бодлоор ТУЗ-ийн гишүүнийг хувьцаа эзэмшигчээс нэр дэвшүүлсэн тохиолдолд ч ТУЗ-ийн гишүүн бүр банк болон түүний бүх хувьцаа эзэмшигчдийн өмнө хариуцлага хүлээдэг. ТУЗ-ийн гишүүн бүр адил цалин урамшуулалтай байх нь зүйтэй. Харин ТУЗ-ийн дарга илүү үүрэг хариуцлагатай тул өөр цалин урамшуулалтай байх бөгөөд ТУЗ-ийн даргын хараат бус байдлыг хангах үүднээс цалин урамшууллын хэмжээ нь зохистой түвшинд байх шаардлагатай. Хэрэв ТУЗ-ийн даргын цалин урамшуулал нь түүний орлогын ихэнх хувийг эзэлдэг болвол хараат бус байдал алдагдах эрсдэл гарч болзошгүй.

Гүйцэтгэх удирдлагаас Хувьцааг нийтэд санал болгох төслийн явц, Хас Лизинг ХХК-ийн ХасБанктай нэгтгэх ажлыг дуусгавар болгосон тухай мэдээлж танилцуулав.

Эдийн засаг, банкны салбарын нөхцөл байдлыг хэлэлцэв.

ТУЗ-ийн хурлаар Банкны 2022 оны төсөв, түүнтэй уялдуулан Гүйцэтгэх захирлын 2022 оны ажлын гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг хэлэлцэж, зарим нэмэлт өөрчлөлт оруулж батлав.

ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд ТУЗ-ийн шийдвэрүүд дээр чөлөөтэй санал бодлоо илэрхийлж санал өгөв.

Хурлын үеэр ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулалыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлэх талаар зөвлөмж гаргахтай холбоотой асуудлаас өөр бусад сонирхлын зөрчилтэй асуудал гарагүй болно.

ТУЗ-ийн гишүүд саналаа чөлөөтэй илэрхийлж, хуралд оролцов.

Лим Сит Чен Лам Пак Нг (Морис Лам)  
2021 оны 12-р сарын 22-ний өдөр

## BOARD AUDIT COMMITTEE MEETING 7<sup>th</sup> December 2021

The quarterly meeting of this Committee was held on 7<sup>th</sup> December 2021, by video conferencing under my chairmanship.

The Committee had already approved the Minutes of the last meeting by circulation. Since there was no matter arising from the minutes, the Committee proceeded with the agenda of the day's meeting.

1. The agenda was approved as per the copy that was circulated prior to the meeting.
2. Ms. Undarmaa, Head of Internal Audit presented the findings of two Internal Audit that had been completed.

### Dashboard based audit of UB branches

Highlights were the high incidence of inappropriate behavior of certain staff, which prompted an exchange among members of the Committee and the CEO regarding the need to properly train new recruits and building a culture of zero tolerance towards these inappropriate behaviors.

### Business Continuity Audit

There was no issue of concern to highlight.

3. Internal audit plan and budget

The Committee approved the audit plan and budget presented while acknowledging the challenge of recruiting and retaining quality audit staff.

4. It was noted that some progress of additional information had been made in the "Related Parties" to be submitted to the central bank.
5. The CRO presented the Quarterly compliance report during which it was highlighted that the Central Bank is increasing enforcing its supervision of banks in this area. The Committee suggested that the bank devote more resources to compliance.
6. External audit of the 2021 year-end financial statements

The chairperson updated the Committee that E&Y's plan is to submit a draft of its Audit report by the end of February/early March 2022.

Prepared and submitted by

Lim Sit Chen Lam Pak Ng (Maurice Lam)



Dated 22<sup>nd</sup> December 2021.

## ТУЗ-ийн Аудитын Хорооны 2021 оны 12-р сарын 7-ны өдрийн хурлын тайлан

Хорооны улирлын ээлжит хурлыг 2021 оны 12-р сарын 7-ны өдөр видео холбооны хэрэгслээр дамжуулан хуралдуулж, хурлыг даргалав.

Хорооны өмнөх хурлын тэмдэглэлийн төслийг имейлээр дамжуулан хэлэлцэж, хурлын тэмдэглэлийг эцэслэн баталсан тухай тэмдэглэв. Өмнөх хурлын тэмдэглэлтэй холбоотой аливаа асууж тодруулах зүйлгүй байсан тул Хорооны хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэв.

1. Хурлаар хэлэлцэх асуудлуудыг урьдчилан тараасан бөгөөд үүний дагуу батлав.
2. ДАГ-ын захирал Э.Ундармаа тухайн улиралд хийж гүйцэтгэсэн хоёр дотоод аудитын тайланг танилцуулав.

Улаанбаатар хотын салбаруудын хяналтын самбарт үндэслэсэн аудит

Салбарын ажиллагсадын дунд зүй бус хандлага их гарч байгааг аудитаар тогтоосон бөгөөд үүнтэй холбогдуулан шинээр ажилд орж буй ажилтнуудыг сургах, зүй бус хандлагыг үл тэвчих соёлыг нэвтрүүлэх шаардлагатай байгааг Хорооны гишүүд болон Гүйцэтгэх захирал хороондоо хэлэлцэж ярилцав.

Бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны аудит

Аудитаар аливаа онцлон тэмдэглэх асуудал гараагүй болно.

3. ДАГ-ын төсөв, аудитын төлөвлөгөө

Хорооны хурлаар ДАГ-ын ирэх жилийн төсөв, аудитын төлөвлөгөөг баталсан бөгөөд аудитын газарт шинээр ажилд авах, сайн ажилтнуудыг авч үлдэхтэй холбоотойгоор гарч буй хүндрэлүүдийг авч хэлэлцэв.

4. Монголбанкинд хүргүүлэх Холбогдох этгээдийн мэдээллийн санд дутуу мэдээллийг оруулах талаар тодорхой ахиц гарсныг тэмдэглэв.
5. Эрсдэл хариуцсан захирал Хянан нийцүүлэх үйл ажиллагааны улирлын тайланг танилцуулсан бөгөөд МБ-наас банкуудын хянан нийцүүлэх үйл ажиллагаанд тавьж буй хяналтыг чангатгаж байгааг тэмдэглэв. Хорооноос Банкны хянан нийцүүлэх үйл ажиллагаанд зарцуулж буй нөөцийг нэмэгдүүлэх талаар зөвлөмж гаргав.

6. 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн хөндлөнгийн аудит

Хөндлөнгийн аудитын Эрнст Энд Янг компани 2021 оны жилийн эцсийн аудитлагдсан тайлангийн төслийг 2022 оны 2-р сарын эцсээр эсвэл 3-р сарын эхээр гаргаж өгөх талаар Хорооны даргын хувьд танилцуулав.

Бэлтгэж танилцуулсан:

Лим Сит Чен Лам Пак Нг (Морис Лам)  
2021 оны 12-р сарын 22-ний өдөр